



1st Story

Мариагаар дамжуулан амлалт биелэлээ оллоо

The Great Announcement



Мариагаар дамжуулан амлалт биеллээ олсон

– 1st Story –

- Хүүрнэгч** Нэгэн өдөр, Назарын Галил гэх тосгонд Мариа гэдэг нэгэн бүсгүй амьдардаг байжээ. Мариа, Иосеф гэх ганц бие залуутай сүй тавьсан байсан учраас удахгүй хийх хуримын бэлтгэлээ бэлдэнгээ машид ихээр догдолж байсан гэдэг. Гэтэл гэнэт тэнгэрээс гялсхийн гэрэлтэж ямар нэгэн юм гарч ирэв! Маш хурдтайгаар ойртон ирээд яг Мариагийн өмнө ирээд зогссон.
- Габриель** Хахаха!! Мариа~~~Бурхан чамтай хамт байгаа~!!
- Мариа** Яадаг билээ!
- Хүүрнэгч** Тэрээр Бурханы илгээсэн тэнгэр элч байлаа
- Габриель** Тэнгэр элч нарын дундах тэнгэр элч Габриель гэгч би байна.
- Хүүрнэгч** Мариа, урьд хожид Габриельтай адил нэгнийг олж харж байсан удаагүй билээ. Тиймээс ч тэрүү маш ихэд айж байлаа.
- Мариа** Га...га.. Габриель? Яагаад яагаад яагаад та энд байдаг билээ? Ми..ми..миний нэрийг яаж мэдсэн юм?
- Габриель** Мариа, бүү ай. Тайван бай. Бурхан чамд үг хэлүүлэхээр намайг илгээсэн юм.
- Мариа** На..на..надад уу?
- Габриель** Тийм ээ, Мариа. Энэ хугацаанд чи итгэлээрээ үнэхээр сайн амьдарч ирсэн болохоор Бурхан Аав үүнд чинь ихэд баярласан гэнэ шүү, Тиймээс Бурхан чиний амьдралыг бүхэлд нь өөрчлөх төлөвлөгөөтэй байгаа. Мариа~чи хэвлийдээ үртэй болж хүү төрүүлнэ. Тэр Хүү төрвөл Түүнийг Есүс гэж нэрлээрэй. Энэ Хүү бол үнэхээр үнэхээр үнэхээр үнэхээр их онцгой Нэгэн шүү. Хамгийн Агуу Нэгний Хүү хэмээн дуудагдах учраас юм. Тэрээр Түүний ард түмнийг үүрд мөнхөд захирах болно. Мөн Түүний хаанчлал нь хэзээ ч төгсөшгүй.
- Мариа** Юу гэсэн бэ? Гэхдээ..... нөгөө юу.... би чинь хараахан хуримаа ч хийгээгүй байгаа. Би би би хүүхэд тээх ямар ч боломжгүй. Энэ чинь байж боломгүй хэрэг болоод байна шүү дээ.



- Габриель** но, но, но ... Бурхантай хамт л бол ямар ч зүйл боломжгүй зүйл гэж байхгүй. Бурхан таныг онгон нэгэн гэх үнэнийг мэдэж байгаа. Хараахан хурим хийгээгүй байгаа гэдгийг ч бас сайн мэдэж байгаа. Гэхдээ Ариун Сүнсээр дамжуулан та жирэмслэх болно. Бурханы хүчээр та Хүүг тээх болно.
- Мариа** Хэн би юу? Би би би Бурханы Хүүгийн эх болно гэж үү?
- Габриель** Тийм ээ, Бурхан чамайг сонгосон юм даа..
- Мариа** ммм..за тэгье. Эзэний намайг сонгосон юм бол би Эзэнд үйлчилье. Бурханы төлөвлөгөө юм бол биелэнэ гэдэгт итгэж байна.
- Габриель** Гайхалтай~~Халлелүяа
- Хүүрнэгч** Ингээд Габриель тэнгэр элч ирсэнтэйгээ адилханаар маш хурдан Мариагаас холдон одов.
- Цаг хугацаа өнгөрсөөр, Габриелийн хэлсэний дагуу Мариа жирэмсэн болов.
- Иосеф** Мариа! Мариа яаж жирэмсэн болов? Би одоо Мариатай хурим хийж чадахгүй болчих шиг боллоо. Энэ чинь урвасан хэрэг биш үү?
- Хүүрнэгч** Тэр шөнө Иосеф унтаж байх үед Тэнгэр элч үзэгдэж Иосефт ийнхүү хэлэв.
- Тэнгэр элч** Иосеф оо, Мариа жирэмсэн боллоо гээд битгий санаа зов. Мариад ямар ч буруу байхгүй. Ариун Сүнс Мариаг жирэмсэн болгосон юм. Мариа Хүү төрүүлэх болно. Есүс хэмээн нэрлэх болно. Есүс том болоод Бурханы ард түмнийг гэм нүглээс нь аврах болно.
- Иосеф** а...а...а...амен.. ойлголоо~!!
- Хүүрнэгч** Дараа өдөр болж Иосеф нойрноосоо сэрэв. Иосеф Мариаг харах үедээ, Мариаг харах төдийд л аз жаргалтай болдог байсан гэсэн.
- Иосеф** Сайн уу, Мариа~~~~
- Мариа** Сайн уу, Иосеф ~~~~